

**СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД

б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Төрийн хяналт шалгалтын тухай хууль, МУЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 10 ны өдрийн А/343 дугаар захирамжаар батлагдсан журмыг тус тус удирдлага болгон 2022 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, төрийн болон орон нутгийн бодлого шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, зөвлөмж арга зүйгээр ханган бодлогын дэмжлэг үзүүлж ажиллах аймгийн хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх найман албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тус суманд 2022 оны 11 дүгээр сарын 06 ны өдөр ажиллаж дүгнэлт зөвлөмж, үнэлгээ өгч ажиллалаа..

Хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүд, хамтарсан баг, ЕБС, СӨБ ын дэргэдэх хүүхэд хамгааллын баг, байгууллагын эцэг эхийн зөвлөлийг ажлын байранд нь чадавхжуулах, зөвлөн туслах, хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээг газар дээр нь шуурхай үзүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ гэр бүл хүүхэд калуучуудын хөгжлийн газрын ажлын хэсэг тус суманд 11 дүгээр сарын 10 ны ажиллаж, ГБХТТ Хууль, Хүүхдийн эрхийн болон хамгааллын тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт, Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагаатай танилцах, Хамтарсан багийн үйл ажиллагаа, кейс шийдвэрлэлт, Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдэд үйлчилгээ үзүүлж буй урьдчилан сэргийлэх үйлчилгээ, Залуучуудын салбар зөвлөлийн үйл ажиллагаа, ЕБС-ийн сурагчдад сургалт мэдээлэл хүргэх, Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдэд тусламж дэмжлэг үзүүлэх зэрэг үйлчилгээ үзүүлж ажиллав.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг 11/23, Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг Засаг даргын зөвлөлийн хурлаар танилцуулан 11 сарын 25 ны өдөр цахим системд тайлагнаж тамгын дарга баталгаажуулан ажиллав.

11 дүгээр сард: Ирсэн бичиг–13, Явсан бичиг – 6, Хариутай бичиг – 5
Хугацаандаа явсан бичиг – 3, Хугацаа болоогүй бичиг – 2, Хугацаа хэтэрсэн бичиг – 0 байна.

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД:

2023 онд ОНХС хөрөнгөөр 14 ажлыг хийхээр 237.0 сая төгрөг батлагдсанаас 11 сарын байдлаар 7 ажил бүрэн хийгдсэн, 3 ажил хийгдэж дуусаагүй, нийтдээ 134.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 32174.6 мянган төгрөг авч орон нутгийн төсвийн байгууллагуудад 57703.7 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Улсын төсвийн 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн 2.5 км хатуу хучилттай авто замын ажлыг Улаанбаатар хотын “ Ханан салхит” ХХК хийж гүйцэтгэж байна.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Залуучуудын хөгжлийн тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудаар тус тус сонсгол мэдээллийн цагаар болон Халзан сумын ЗДТГ-ын албан ёсний вэб хуудсаар дамжуулан мэдээлэл өгч ажиллалаа.

Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Шүүхийн тухай ойлголт, Зөвшөөрлийн тухай хууль, Хууль зүйн туслалцааны төвийн тухай хуулиудын чиглэлээр 11 дүгээр сарын 25 ны өдөр аймгийн хууль зүйн хэлтсээр цахимаар зохион байгуулагдсан сургалтад хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн, эрх зүйн хөтчөөр бэлтгэгдсэн 2 иргэн хамрагдлаа.

Тэгш боломжийн төлөөх залуучуудын манлайлал сургалт болон Өсвөр насны охид, хөвгүүдийг өөрсдийн тулгарч буй жендэрийн асуудлыг ойлгох, үр дагаврыг нь бодож ухаарах, шийдэх арга замаа өөрсдөө олж тодорхойлоход сургах. Сургалтад хамрагдсан охид хөвгүүдийн үйл ажиллагаагаар дамжуулан жендэрийн тэгш байдлын талаарх ойлголт мэдлэгийг сурагчдад болон малчин залуучуудад түгээн дэлгэрүүлэх зорилготой юм. Малчин залуучуудад, Эрүүл мэндээ хамтдаа хамгаалцгаая, Аз жаргалтай гэр бүлийг бүтээцгээе гэсэн сэдэвт сургалт, Өсвөр насны охид, хөвгүүд ирээдүйн мэргэжлээ сонгохдоо жендэрийн хэвшмэл ойлголтоор хандахгүй байхад суралцахаас гадна үе тэнгийнхэн, багш нартаа мэдлэг ойлголт өгөх зорилгоор ЕБС ын ахлах ангийн сурагчдад : Мэргэжилд хүйс хамаатай юу, Хөвгүүд бие биедээ үлгэрлээ, Охид нэгнээ хамгаалж дэмжицгээе ! гэсэн сэдвүүдийн хүрээнд сургалтуудыг 11 дүгээр сарын 10 ны өдөр ГБХЗХГ аас тус тус зохион байгуулан ажиллалаа.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Ерөнхий боловсролын сургууль: 11-р сарын 5нд сургуулийнхаа нийт ангиудын дунд “Бидний авьяас-2022” урлагийн наадамыг амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд нийт 10 бүлгийн 220 сурагч 7 төрлөөр өрсөлдөж шилдгүүдээ тодруулсан. 11-р сарын 26-27ны өдрүүдэд зохион байгуулагдах “ХУН” урлагийн наадамд 20 сурагчийн бүрэлдэхүүнтэйгээр оролцохоор бэлтгэл ажлаа хангаж ажиллаж байна.

Сүхбаатарын өнгө сонины 5 жилийн ойд зориулан зохион явуулсан “Яруу найргийн үдэш “ шүлгийн тэмцээний 1-р шатыг соёлын төвтэй хамтран зохион байгуулж , 2-р шатанд 7 сурагч оролцсоноос 8а ангийн сурагч М.Үүрийнцолмон 3-р байр эзэлсэн.

Аймгийн үндэсний бөхийн холбооны нэрэмжит өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах үндэсний бөхийн тэмцээнд 3 а ангийн сурагч Цогтгэрэлийн Хатанбүүвэй "ДЭД" байр эзэлж МӨНГӨН медаль эзэлсэн. Мөн МХБХ-ны “Хөвгүүдийн цом- 2022” УАШТ-нд 9а ангийн сурагч Э.Амгаланбаатар мөнгөн медаль хүртсэн.

Боловсролын үнэлгээний төвөөс 11-р сарын 13-16-ны өдрүүдэд Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг зохион явуулсан. Уг үнэлгээнд эцэг эх, багш сурагчид түүврийн аргаар асуулгад хамрагдсан.

Байгууллагын эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор сургуулийн гадна тал болон давхар бүрт 2400000₮-ний өртөг бүхий сүүлийн үеийн камерыг суурилуулсан.

Багш нарт эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор 17 багшийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. 4 чиглэлээр \ Цагаан хорхой, бамбай, дууны хөвч, хеликобактери \

Соёлын чиглэлээр: “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулж буй СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР-ын үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулж Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, бүх нийтийг соён гэгээрүүлэх, Соёлын бүтээлч үйлдвэрлэл, Соёлын аялал жуулчлалаар дамжуулан орон нутгийн тогтвортой хөгжлийн хангах, иргэд, албан байгууллага, аж ахуй нэгжийн оролцоог хангах "СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР" 11 сард амжилттай болж өндөрлөх шантандаа явж байгаа бөгөөд сумын ард иргэдийг соёл урлагийн чиглэлээр хөгжүүлэх хамтран ажиллах, соёл урлагт дуртай сонирхолтой болгоход нилээдгүй ажлыг зохион байгуулан ажиллаа.

Мөн Жилийн эцэс болж буйтай холбоотой санхүүгийн чиглэлээр үндсэн үйл ажиллагаандаа ашиглагдах хөрөнгө санхүүг зөв зохистой ашиглаж бүтээлч ажил хийхээр төлөвлөн Соёлын төвийн Дарга Г.Баяржаргал Тайзны чимэглэл хөшиг клүүз гэрэл гэрэлтүүлгийн асуудлыг хариуцан ажиллаж тайзны засал чимэглэлийг амжилттай хийж дуусгалаа.

Номын сангийн уншлагын танхимаар 21 уншигч үйлчлүүлсэн бөгөөд үүнээс сургуулийн насны 17 хүүхэд, насанд хүрэгч 4 иргэн үйлчлүүлж гэрээр ном олгох үйлчилгээнд 6ш ном олгосон байна. Албан байгууллага, аж ахуй нэгжүүдийн дунд “Номын садан байгууллага” номын санг моод болгое уралдааныг зарлаж Тэргүүн байранд хүүхдийн цэцэрлэг, Дэд байранд ЕБС тус тус шалгарлаа. Соёлын аялал жуулчлалын хүрээнд зохион байгуулагдах хүүхдийн номын санг үүсгэн байгуулагч зөвлөх багш Батцэцэгийг сумандаа урьж ЕБС-ийн сурагчдад “Хүүхэд бүр номтой нөхөрлөөсэй” лекц сургалт авах ажлыг зохион байгууллаа. Мөн алслагдсан багийн иргэдэд соёлын үйлчилгээг хүргэх зорилгоор Г.Ууганбаяр даргатай Сахиулын 2 дугаар багт хүрч ажиллаа. Энэ үеэр явуулын номын сангаа ажиллуулж 2 иргэнд шинээр карт нээж, 8 номыг гэрээр олгох үйлчилгээнд гаргасан бөгөөд урлагын номер, үдшийн цэнгүүний арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.

СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР: Монгол улсын хэмжээнд бүртгэлтэй ТСҮХД зүйлийн нэг болох Цагаан эргийн хөшөө чулууг хамгаалалтанлд авч хашаажуулах ажлыг зохион байгуулан ажиллаа. Улсын хэмжээнд Соёлын биет бус өвийн үзлэг, судалгааны асуулга явагдаж байгаатай холбоотой Соёлын төвийн БМС-нд бүртгэлтэй өв тээгч нарын судалгааг биеэчлэн авах болон цахим хэлбэрээр судалгааны ажлыг хийж байна. Улсын хэмжээнд Соёлын биет бус өвийн үзлэг, судалгааны асуулга явагдаж байгаатай холбоотой Соёлын төвийн БМС-нд бүртгэлтэй өв тээгч нарын судалгааг нэг бүрчлэн авч бүртгэлтэй байгаа 19 өв тээгч нарын судалгааг тусгай программд бүрэн шивж дуусгалаа. Мөн ЕБС-ийн дотуур байрны багш, ажилчид эцэг эхчүүдтэй хамтран дотуур байрны

сурагчдад “Өв соёл бидний бахархал” үзэсгэлэн гаргаж, үндэсний дээлээр гоёсон үдэшлэгийн арга хэмжээг зохион байгууллаа.

Дуу хөгжмийн багш, бүжгийн багш нарын хамтран зохион байгуулж байгаа “Дарьганга марзай, Уртын дууны айзам” сургалт 7 хоног бүрийн 4 дэхь өдөр зохион байгуулагдахаар төлөвлөгдөж эхний өдрийн сургалтанд ЕБС-ийн 4,5 анги болон дунд ангийн нийт 20 гаруй хүүхдийг бэлтгэн сургаж эхэллээ.

Соёлын төвд бусад байгууллагын хамтарсан үйл ажиллагаа 5 удаа зохион байгуулагдсан байна.

11 сарын 06- ны өдөр ЕБС-ийн хүүхдүүдийн Урлагийн наадмыг зохион байгуулахаар ажиллаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: Эрүүл мэндийн төв нь 10 сарын 1 наас ковид -19 батлагдсан тохиолдол нийт 7 бүртгэгдсэн. Гэрийн эмчилгээнд 6 хүн байсан Заавар зөвлөмжийг өгсөн. Ковидоор хэвтэн эмчүүлж тасагт 0. А Аминдэмийг 0- 5 насны 100 хүүхдэд уулгасан .АНЭ ийн дотрын эмч болон Гепатитгүй төслийн хүрээнд элэгний С вирусийн халдвартай 73 иргэнээс идэвхижил тоолуулаагүй 35 иргэдийг АНЭ лабораторийн тасагт өөрсдийн биеэр болон өндөр настай 21 иргэний цусийг авч явуулсан. Үүний үр дүнд 4 хүн эмчилгээнд хамрагдсан Бусад нь С вирус нь идэвхигүй байсан. Эрт илрүүлгийн багцад хамрагдах 18- 34 насны иргэдийн бүртгэл судалгааг АНЭ илгээсэн.

Хүнс хөдөө аж ахуйн жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр:

2022 оны 11-р сарын 25-ны байдлаар нийт 4 зээлдэгч байгаагаас 2022 оны 11 сарын зээлийн эргэн төлөлтийн орлого 4 зээлдэгчээс 1,856,257 мянган төгрөгний орлого Сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлсэн байна. Нийт зээлдүүлэгч нартай утсаар болон биеэр очиж уулзан хугацаандаа зээлээ эргэн төлөх талаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.

Санхүү аудитын газраас ирсэн албан даалгавар, шалгалтын хариу дэлгэрэнгүй тайланг явууллаа. Сумын хүнсний гол нэрийн нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг 1 аймгийн ХХААГазарт мэдээлж байна.

Аймгийн мэргэжлийн хяналтын газартай хамтран хүнсний худалдаа эрхлэдэг 5 аж ахуй нэгж, мал бэлтгэлийн газар, хоол үйлдвэрлэлийн 3 газарт зөвлөн туслах, сургалтыг зохион байгуулж ажиллалаа.

ХХАА-н чиглэлийн ажлаар: Малын үзлэг ангилал, эмээгжүүлэлтийн бичмэл тайлан, Малчдын зөвлөгөөний бичмэл тайланг ХХААГазарт илгээлээ. Мөн сумын 2022 оны гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ хангамжын судалгааг гаргаж явууллаа.

Мал эмнэлэгийн чиглэлээр: Шүлхий өвчнөөс сэргийлэх 21000 тун вакцин татан авч сумын засаг даргын 2022 оны 10 сарын 18 ны өдрийн А/135 тоот захирамжийн дагуу 5 хэсэг гарч 230 өрхийн 14124 үхэр, 6800 тугал, нийт 20924 мал хамрагдахаар хувиар хийгдсэнээс 15851 үхэр хамрагдаад байна. Шинээр

Сахиулын 2-р багт “Талын ажнай хүлэг”ХХК байгуулагдаж 30 малчин өрхтэй гэрээ байгуулж, анхан шатны баримт материал , МЭНС-ийн асуумжийн дагуу зураг тайлбарыг хавсарган 30 асуултнаас 26 оноо буюу 80 хувьтай дүгнэж дүгнэлт гаргасан. Гоц халдварт өвчний эрсдлээс сэргийлэх зорилгоор мал аж ахуйн албан татвараас 20 сая төгрөгөөр малын тарилгын хашаа худалдан авч мал эмнэлгийн үйлчилгээнд хэрэглэх хашааг бүрэн хийж гүйцэтгээд байна.

Байгаль орчны чиглэлээр: ОНХС-ийн 20 сая төгрөгийн хөрөнгөөр төвлөрсөн хогийн цэгийг хашаажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн Мөн Жарын овооны хогийг цэвэрлэж. 2 тонн хогийг авчирч төвлөрсөн хогийн цэгт байршуулав. Төвлөрсөн хогийн цэгийн хогийг ковшоор түрж 4 га газрын хогийг түрж чөлөөлөв.

ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА:

М.БАТБЭХ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Д.ДАЙРИЙМАА